



БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2016/4



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

www.1212.mn



**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН**





www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.



Monstat ezStat
аппликейшн





1900-1212
Лавлах утас



@statistic_mn
**Статистик
мэдээлэл**



Үндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН



**Онлайн лавлах
мессенжер**
8:30-17:30

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

**ХҮНД СУРТАЛ
АВИЛГА**

**ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ**

ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	6
Үндсэн үзүүлэлтүүд.....	13
I. 1 Хөдөлмөр	14
I. 2 Нийгмийн даатгал, нийгмийн халамж.....	15
I. 3 Эрүүл мэнд	16
I. 4 Гэмт хэрэг	16
II.2 Үнэ.....	18
II.6 Аж үйлдвэр.....	24
II.6 Мал аж ахуй.....	25

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - i барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - i барааны суурь үеийн үнэ,

q_{io} - i барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum - нийлбэрийн тэмдэг

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Хүн ам

2016 оны эхний 4 сарын байдлаар иргэний бүртгэлийн мэдээллийн санд шинээр төрсөн 410 хүүхэд, нас барсан 168 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс төрөлт 2.2 хувиар буурч, нас баралт 31 хувиар өсчээ.

Эх сурвалж: УБСГазрын Иргэний бүртгэлийн мэдээ

Зураг I.1.1


Бүртгэгдсэн төрөлт, нас баралт, ердийн өсөлт жил эхний бүрийн 4-р сарын байдлаар



Оны эхний 4-р сарын байдлаар 613 хүн шилжин ирж, 403 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 96 буюу 18 хувиар, шилжин явсан хүн 53 буюу 15 хувиар тус тус өссөн байна.

Зураг I.1.2

Шилжих хөдөлгөөн, механик өсөлт, жил бүрийн эхний 4-р сарын байдлаар



I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэд 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 764 болсны 347 нь эмэгтэйчүүд байна.

Тайлант хугацаанд 314 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 34 иргэн ажилд зуучлагдан орж, 175 иргэн ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс шинээр бүртгүүлсэн ажилгүй

иргэнд 19 хүн буюу 5.7 хувиар буурч, ажилд зуучлагдан орсон иргэд 8 хүн буюу 30.8 хувь, ажил идэвхитэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 51 хүнээр буюу 41.1 хувиар өсчээ.

Зураг I.2.1

Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд 4 дүгээр сарын байдлаар



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.1 хувийг Магистр болон докторын зэрэгтэй, 15.8 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 6.0 хувийг тусгай мэргэжлийн дунд, 8.0 хувийг техникийн болон мэргэжлийн, 55.6 хувийг бүрэн дунд боловсролтой, 10.3 хувийг суурь боловсролтой, 3.3 хувийг бага боловсролтой, 0.9 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр 2016 оны 4 дүгээр сарын



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 19.6 хувийг 15-24 насны, 34.4 хувийг 25-34 насны, 24.3 хувийг 35-44 насны, 16.4 хувийг 45-54 насны, 3.2 хувийг 55-59 насны, 2.1 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.



I.3. Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны 4 сард 3869.5 сая төгрөг, зарлага 9938 сая төг болж өмнөх оны мөн үеийнхээс орлого 491.2 сая төг буюу 14.5 хувиар, зарлага 487 сая төг буюу 5.2 хувиар тус тус өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого 491.2 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэмжийн даатгалын сангийн орлого 16.5 сая.төг буюу 6.6 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 6.2 сая.төг буюу 10.7 хувиар, тэтгэврийн даатгалын сангийн орлого 197.7 сая.төг буюу 9.1 хувь, эрүүл мэндийн даатгалын сан 256.2 сая.төг буюу 35.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 487 сая.төг буюу 5.2 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 481 сая.төг буюу 5.9 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 58.8 сая.төг буюу 8.5 хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 26.6 сая.төг буюу 43.5 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Харин тэтгэмжийн даатгалын сан 52.5 сая.төг буюу 13.7 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 26.9 сая.төг буюу 18.5 хувиар буурсан байна.

Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны 4 сарын байдлаар 5022 хүн 1145.3 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгож, өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 21.5 сая.төг буюу 1.9 хувиар өсчээ. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1116 хүн хамрагдаж 549.6 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 4.6 сая.төг буюу 0.8 хувиар буурсан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2016 оны 4 сарын байдлаар 1511 хүн хамрагдсаны 21.6 хувь нь ахмад настан, 71.5 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 5.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 1.7 хувь нь алдар цолтой ахмад настай иргэд байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 82.0 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 0.6 сая.төг буюу 0.8 хувиар буурсан байна.



I.4 Эрүүл мэнд


Аймгийн эмнэлгүүдэд 2016 оны эхний 4 сарын байдлаар 290 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн

тоо 290 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 70 буюу 24.1 хувь, амьд төрсөн хүүхдийн тоо 69 буюу 23.7 хувиар буурсан байна.

Эх сурвалж: Эрүүл мэндийн газрын мэдээ

Зураг I.4.1


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, сүүлийн 3 жилийн 4-р сарын байдлаар



Нялхасын эндэгдэл 2016 оны эхний 4 сарын байдлаар 4 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 буюу 25 хувиар буурсан байна.

Зураг I.4.2

Эндсэн хүүхэд, сүүлийн 3 жилийн 4-р сарын байдлаар





1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2016 оны эхний 4 сарын байдлаар 4 тохиолдол, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл одоогоор гараагүй байна.

Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2016 оны эхний 4 сарын байдлаар 337 болж, өмнөх оны мөн үеийнхээс 184 тохиолдол буюу 54.5 хувиар өссөн байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 260 буюу 77.1 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 61 буюу 18.1 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг I.4.3

Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сүүлийн 3 жилийн эхний 4-р сарын байдлаар



1.5 Байгаль орчин Цаг уурын урьдчилсан мэдээ

Тавдугаар сард. Агаарын температурын сарын дундаж нь 10-15 градус дулаан буюу нийт нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

Сарын эхэн болон 8-15-нд сэрүүсч шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан байна. Сарын сүүлээр бага зэрэг сэрүүсч шөнөдөө 0-5 градус, өдөртөө 10-15 градус дулаан байна. 18-22, 25-ны үеэр Орхон, Сэлэнгийн хөндийгөөр шөнөдөө 9-14 градус, өдөртөө 24-29 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 19-24 градус хүрч дулаарна. Бусад хугацаанд шөнөдөө 1-6 градус, өдөртөө 17-22 градус дулаан байх төлөвтэй.


Энэ сард нутгийн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.

Сарын эхэн болон 8-15-нд зарим газраар хур тунадас, уулаараа нойтон цас орно. 25-н болон сарын сүүлээр ихэнх нутгаар бороо, уулаараа хур тунадас орох төлөвтэй. Дуу цахилгаантай.

Дээрх үеүдэд салхи нутгийн өмнөд хэсгээр 12-14 м/с, ялангуяа сарын эхэн ба дунд үе, 25-ны үеэр зарим үед 16-18м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

Зураг 1.5.1

5-р сарын агаарын температурын хоногийн



Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөх тухай: 2016 оны 5 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим, мөн хур тунадас ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим ба түүнээс ахиу орох төлөвтэй байна.

5 дугаар сард ихэнх нутгаар шөнөдөө жиндүү хүйтэн, үе үе хүчтэй шороон шуурга шуурч бэлчээрийн ургамлын ургалтыг удаашруулахын дээр малын хариулга маллагаанд таагүй нөлөөлөх тул онцгой анхаарна уу.

Гол мөрний усны түвшин ба урсацын урьдчилсан мэдээ: Монгол орны ихэнх гол мөрний усны түвшин тухайн сарын олон жилийн дунджаас бага ба түүний орчим байх төлөвтэй байна. Тухайлбал 5 дугаар сард Хөвсгөлийн уулсаас эх авсан Эг гол болон Хэнтэй нурууны баруун хажуугаас усжих Туул голуудын усны түвшин олон жилийн дунджаас 10-50 см бага байх төлөвтэй байна. Ихэнх гол мөрний усны түвшин олон жилийн дунджаас бага ба түүний орчим байх төлөвтэй байгаа бөгөөд 5 дугаар сарын дунд үеэр зарим томоохон голын усны түвшин өмнөх өдрийнхөөс 5-20 см нэмэгдэх төлөв ажиглагдана.

Манай орны гол мөрний хаврын шар усны үерийн оргил үе гол төлөв 5 дугаар сарын эх ба дунд үеэр ажиглагддаг боловч энэ жилийн хувьд онцгой үер ажиглагдахгүй.

Хүснэгт 1.5.1

Зарим гол мөрний 2016 оны 5 дугаар сарын урсацын прогноз

	Гол мөрөн, харуулын нэр	5-р сарын олон жилийн				5-р сард ажиглагдах	
		Дундаж		Өнгөрөлт		дундаж	
		Түвшин	Өнгөрөлт м3/с	Хамгийн их м3/с	Хамгийн бага м3/с	Түвшин м3/с	Өнгөрөлт м3/с
1	Сэлэнгэ мөрөн хялганат баг	225	439	866	257	260	390
2	Орхон гол орхон сум	160	42.9	99.6	14.8	150	55.0

Зургаадугаар сард. Агаарын температурын сарын дундаж нь нутгийн төв болон хойд хэсгээр уур амьсгалын дунджаас 1.0-1.5 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй. Энэ сард нийт нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.




I.6 Гэмт хэрэг

2016 оны эхний 4 сарын байдлаар 102 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5 хэргээр буюу 4.6 хувиар буурсан байна. БҮСТЗЭТХэрэг 39 бүртгэгдэн 24 хэргийг илрүүлэлт 61.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.4 хувиар буурсан.

Зураг I.6.1

Бүртгэгдсэн гэмт хэрэг, жил бүрийн эхний 4-р сарын байдлаар



Хэргийн өнгөөр нь авч үзвэл


- ИЭЧЭМЭГХ 35 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 хэргээр буюу 10.2 хувиар
- Танхайрах гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 хэргээр буюу 50 хувиар
- ХАБАЖЭГХ 8 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 3 хэргээр буюу 37.5 хувиар
- БХЖЭГХ 1 бүртгэгдэн урьд оны мөн үеийнхээс 2 хэргээр буюу 100 хувиар
- Хулгайн гэмт хэрэг 36 бүртгэгдсэн өмнөх оны мөн үеийнхээс 6 хэргээр буюу 14.2 хувиар, үүнээс мал хулгайлах хэрэг 13 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 14 хэргээр буюу 51.8 хувиар буурчээ.
- Хүнийг санаатай алах гэмт хэрэг 4 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 100 хувиар
- Хүчиндэх гэмт хэрэг 6 бүртгэгдэн урьд оны мөн үеийнхээс 100 хувиар тус тус өсч
- Албан тушаалын эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэн өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 250.7 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 200.0 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 188.2 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж ажилласан.

Зураг I.6.2


Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн эхний 4-р сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас 20 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 4 дахин өссөн байна. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн улмаас 6, бусдыг санаатай алах гэмт хэргийн улмаас 4, бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн улмаас 1, ХАБАЖЭГХ –ийн улмаас 6 иргэн тустус амь насаа алдсан байна. Гэмт хэргийн улмаас 44 хүн гэмтсэн нь ИЭЧЭМЭГХ –ын улмаас 35, ХАБАЖЭГХ –ийн улмаас 5 хүн, бусад хэргийн улмаас 8 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 7 буюу 13.7 хувиар буурсан байна.

Зураг I.6.3

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан, жил бүрийн эхний 4-р сарын байдлаар



Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар: 2016 оны эхний 4-н сарын байдлаар гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 217 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 15 хүнээр буюу 7.4 хувиар өссөн бол, захиргааны журмаар 14 хүнийг баривчилж шийтгэл эдлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 69 хүнээр буюу

79.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна . Сogтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 104 иргэн байна.



II. Эдийн засгийн үзүүлэлт


II.1 Аймгийн төсөв

Орон нутгийн төсвийн нийт орлого 2016 оны эхний 4-р сарын байдлаар 15631.8 сая төгрөг, зарлага 15828.1 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 196.3 сая төгрөгний сөрөг гарлаа.

Орон нутгийн төсвийн орлогын 35 хувийг татварын орлого, 2 хувийг татварын бус орлого, 64 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Аймгийн төсвийн зарлагын хэмжээ 2016 оны эхний 4 сарын байдлаар 15828.1 сая.төг болоход 71 хувь буюу 11262.6 бараа материалын зардал, 29 хувь буюу 2067 сая. төг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг II.1.1


Аймгийн төсвийн орлого, зарлага жил бүрийн эхний 4-р сарын байдлаар, сая төг



Нийт авлага 36.0 сая, өглөг 631.0 сая төгрөг байна. Нийт өглөгөөс цалин, НДШ-ийн өр 92.0 сая төг, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өр 456.1 сая, эмийн өр 8.2 сая, бусад зардлын өглөг 74.7 сая төгрөг байна.

Зураг II.1.2

Аймгийн төсвийн өр, авлага сараар




II.2 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 2016 оны 4-р сард өмнөх сарынхаас 1.4 хувиар, оны эхнээс 2.2 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 1.5 хувиар тус тус өсчээ.

Зураг II.2.1

Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)



Хүснэгт II.2.1


Хэрэглээний үнийн аймгийн индекс (суурь үе буюу 2010-XII=100хувь)

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2016 IV 2015 IV	2016 IV 2015 XII	2016 IV 2016 III
Ерөнхий индекс	100.0	101.5	102.2	101.4
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	104.9	111.0	107.9
Согтууруулах ундаа, тамхи	3.2	100.4	98.8	98.7
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	95.1	100.0	99.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	105.9	101.9	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	100.1	99.6	100.6

Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	99.2	100.0	100.0
Тээвэр	12.2	99.8	98.6	99.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	99.9	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	99.4	99.6	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	132.5	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	103.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	104.0	101.4	100.3

Зураг II.2.2

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2015 оны I-XII, 2016 оны I-III сар (өмнөх сар=100%)



Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2016 оны 4 сард адууны шир 12.5 мян.төгрөг, үхрийн 1.8-2.3 м урттай шир 10.0 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 17.5 мян.төгрөг байна. Өмнөх оны мөн үеийнхээс адууны шир 66.2 хувиар, үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 71.4 хувиар, 2.3 метрийн урттай шир 65 хувиар буурсан байна.

Малын дундаж үнэ: 2016 оны эхний 4 сард тэмээ 780 мян.төг, адуу 647 мян.төг, үхэр 866 мян.төг, хонь 120 мян.төг, ямаа 86 мян.төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс тэмээ 30.9 хувиар, адуу 23.9 хувиар, үхэр 30.1 хувиар, хонь 26.1 хувиар, ямаа 23.3 хувиар тус тус буурчээ.




II.4 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 4 сарын байдлаар 2619.0 сая.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 531.4 сая. төг буюу 25.4 хувиар өссөн байна. Үүнд боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 275.1 сая.төг буюу 20.8 хувиар өссөн нь нөлөөлж байна.

Зураг II.4.1

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт жил бүрийн эхний 4 сарын байдлаар



- Цахилгаан дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж
- Боловсруулах аж үйлдвэр
- Уул уурхай, олборлох аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбар нь 2016 оны эхний 4 сарын байдлаар 3817.9 сая төгрөгний бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 528.4 сая.төг буюу 12.5 хувиар буурсан байна. Нийт борлуулалтын 491.3 сая төг буюу 12.9 хувийг уул уурхай салбар, 1917.5 сая төг буюу 50.2 хувийг боловсруулах аж үйлдвэрийн салбар, 1409.1 сая төг буюу 36.9 хувийг цахилгаан дулааны борлуулалт эзэлж байна.




II.6 Тээвэр

2016 оны эхний 4-р сарын байдлаар аймаг дотор, хот хооронд 9.3 мянган хүн зорьчиж 3.2 мянган тонн ачаа тээвэрлэж, ачаа тээврийн орлого 6385.5 мян.төг болжсон байна.

Зураг II.6.1

Тээсэн ачаа, зорчигчдын тоо жил бүрийн 4-р сарын байдлаар



- Тээсэн ачаа, мян.тн
- Зорчигчдын тоо, мян.хүн



II.7 Аж ахуй нэгж, байгууллагын улсын тооллогын мэдээлэл

Монгол Улсын “Статистикийн тухай хууль”-д аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жилд нэг удаа явуулж байхаар заасны дагуу Засгийн газрын 2016 оны 3-р

сарын 21-ний 163 дугаар тогтоолын дагуу 2016 оны 4-р сарын 1-нээс орон даяар зохион байгуулан явууллаа.

Тооллогын зорилго нь: Аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын тоог бодитой тодорхойлж, статистикийн мэдээлэлд бүрэн хамруулах, тэдний байршил, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл, улс орны эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тогтоох үндсэн дээр улсын эдийн засгийн чиг хандлагыг тогтооход оршиж байна. Энэ удаагийн аж ахуйн нэгжийн тооллогыг явуулах технологийн хувьд бүртгэлд суурилсан аргыг голлож мөн уламжлалт аргыг хослуулан явууллаа. Гааль, татварын ерөнхий газрын мэдээллийн санд үндэслэн онлайнаар татварын тайлангаа тайлагнадаг аж ахуйн нэгж, байгууллагууд шууд тооллогод хамрагдлаа.

Аймгийн хэмжээнд урьдчилсан байдлаар 1386 аж ахуй нэгж байгууллага тооллогод хамрагдсан ба 427 аж ахуй нэгж байгууллагыг уламжлалт аргаар, 939 аж ахуй нэгж байгууллагыг онлайнаар тооллоо. Нийт тоологдсон аж ахуйн нэгж байгууллагын 100 буюу 7.2 хувь нь татан буугдахаар хүлээгдэж байгаа, эзэн нь нас барсан албан ёсны өмчлөгч байхгүй, бусад зэрэг шалтгаантай байна.



**II.8 Хөдөө аж ахуй
Мал төллөлт, төл боожилт**

2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1444.7 мянган хээлтэгч малын 934.4 мянга буюу 64.7 хувь нь 2016 оны эхний 4 сард төллөсөн байна. Эм ямааны 68 хувь, эм хонины 74.1 хувь, ингэний 19.3 хувь, үнээний 24 хувь, гүүний 9.2 хувь төллөжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал мал төллөлт 3.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гарсан төлийн 97 хувь буюу 906.3 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал 2.1 хувиар өссөн байна.

Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2016 оны эхний 4 сарын байдлаар 40.7 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 4.4 мян. толгой мал буюу 9.8 хувиар буурсан байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 3.8 мянга буюу 9.5 хувь, үхэр 5.4 мянга буюу 13.5 хувь, хонь 17.1 мянга буюу 42.1 хувь, ямаа 14.2 мянга буюу 34.9 хувь

буюу оны эхний малын 1.3 хувь нь тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын дийлэнх 77 хувийг ямаа, хонь эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Рашаант сум 23.8 хувийг, Гурванбулаг сум 17.1 хувь, Дашинчилэн сум 14.2 хувь, Баяннуур сум 11.4 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна. Өвчнөөр хорогдсон мал 484 болж өмнөх оны мөн үеийнхээс 1030 толгой мал буюу 68 хувиар буурсан байна.


Зураг II.8.1

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, 2016 оны эхний 4 сарын байдлаар, толгой



Зураг II.8.2

Том малын зүй бусын хорогдол, 2016 оны эхний 4 сарын байдлаар



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1.

Үзүүлэлтүүд	2014 I-IV	2015 I-IV	2016 I-IV	2016 I-IV 2015 I-IV
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд				
Төрсөн хүүхэд	360	360	290	80.6
Бүртгэлтэй ажилгүй иргэд 4 дугаар сарын эцэст	546	732	903	123.4
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	266	153	337	220.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	108	107	102	95.3
Нийгмийн даатгалийн орлого	2981	3378.3	3869.5	114.5
Нийгмийн даатгалийн зарлага	6475.9	8172.6	8653.6	105.9
Макро эдийн засгийн үзүүлэлтүүд				
Орон нутгийн төсвийн орлого, сая.төг	11133.9	17650	15831.6	89.7
Орон нутгийн төсвийн зарлага, сая.төг	10729.1	9230.8	15828.1	171.4
Адууны дундаж үнэ /нас гүйцсэн/	-	809	604	74.7
Үхэрийн дундаж үнэ /нас гүйцсэн/	-	996	747	75.0
Тэмээний дундаж үнэ /нас гүйцсэн/	-	1129	780	69.1
Хониний дундаж үнэ /нас гүйцсэн/	-	122	92	75.4
Ямааны дундаж үнэ /нас гүйцсэн/	-	95	67	70.5
Эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд				
Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, жил бүрийн 4-р сарын байдлаар, сая.төг	593.2	1717.1	910.5	53.0
-Уул уурхай, олборлох аж үйлдвэр	91.7	0	131	0
-Боловсруулах аж үйлдвэр	106.5	1307.6	346.6	26.5
-Цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамж	395	409.5	432.9	105.7

I.2 ХӨДӨЛМӨР

Хүснэгт I.2.1 Хөдөлмөр

Үзүүлэлт	2015 IV		2016 IV		$\frac{2016 IV \%}{2015 IV}$	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эхэнд/	523	276	764	347	146.1	125.7
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн	333	177	314	136	94.3	76.8
Тайлант хугацаанд хасагдсан иргэн /идвэхгүйн улмаас/	124	63	175	93	141.1	147.6
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	732	390	903	390	123.4	100.0
